

Монгол : Өсөлтийн эх үүсвэрүүд **Монгол улсын эдийн засгийн Санамж бичиг**

Баялаг бүтээх болон бараа материалын хангалтын эх үүсвэр нь хуучнаар ЗХУ-ын үед тус улсаас шууд хамаарах нь байнга өссөөр ирсэн Монгол улсын эдийн засаг Зөвлөлтийн холбоо төгсгөл болсны улмаас томоохон бэрхшээлтэй тулгарсан. Уг бэрхшээлийн илрэл нь 1992 онд инфляцийн өсөлт даруй гурав дахин (300%) нэмэгдсэн явдал байв.

Завсрын үе буюу 1990-1993 оны хооронд бүтээгдэхүүний хэмжээ 20%-иар буурч хүн амд ноогдох ДНБ-ний өсөлт доогуур түвшинд хүрсэн байжээ.

Тэгвэл өнөөдөр Монгол улс амсхийх чөлөөгүй тулгарсан хатуу ширүүн үеийг макро эдийн засгийн найдвартай гүйцэтгэлтэйгээр өөрөөр хэлбэл мөнгөний хязгаарлалтын стратегиудыг хэрэгжүүлэн инфляцийг 7%-ийн дундаж түвшинд барьж ДНБ-ний өсөлтийг ойролцоогоор 7,5%-д хүргэж 2006 оны байдлаар харьцангуй хэвийн түвшинд хүргэсэн амжилтаар туулан гарчээ.

Тогтвортой байдал шинэчлэлийн гол бүрэлдэхүүн хэсэг болох нь 1996 оны сүүл үеэс буюу банкны системд бүтцийн өөрчлөлт хийх, дотоод хүүгийн түвшинг өсгөх, санхүүгийн хатуу бодлого баримтлах зэргээр шинэчлэлийг хэрэгжүүлэх явцад тодорхой болсон байна. Энэхүү макро эдийн засгийн шинэчлэл нь үнийн либералчлал тогтоох, хувьчлал явуулах, зах зээлийн институцуудыг бий болгох зэрэгт голчлон чиглэгдсэн ажээ. Үүнтэй зэрэгцэн, бий болсон ядуурлыг бууруулах шинэчлэлийн тусгай хэлбэрүүдийг хэрэгжүүлсэн.

Хэдийгээр 1990-ээд оны эхэн үе хүртэл эдийн засагт мал аж ахуйн салбар зонхилж байсан ч 2005 оны байдлаар нэмүү өртгийн дундаж өсөлт нь 9,1 %-д хүрсэн үйлчилгээний салбарын томоохон өөрчлөлт зөвхөн сүүлийн таван жилийн дотор тохиолджээ. ДНБ-ний бодит өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйлс нь алт зэс, ноолуур гэх мэт цөөн нэр төрлийн бараа бүтээгдэхүүний экспорт буюу уул уурхай, мал аж ахуйн салбарын өсөлт байсан.

Монгол улсын газарзүйн таатай бус байршил нь нэлээд саад тотгор үүсгээд зогсохгүй “алслагдсан тусгаарлагдмал” байдалд оруулдаг ажээ. Хөрш зэргэлдээ улсуудтайгаа нэгдмэл харилцаа, худалдааг хөгжүүлэхэд үр ашиггүй тээвэрлэлт болон түгээх үйлчилгээнээс шалтгаалсан бэрхшээлүүд гардаг. Эдийн засгийн өсөлтөд авилгатай тэмцэх, дэд бүтцийг сайжруулах, эхийн эндэгдлийг бууруулах зэрэг асуудалд хөдөөгийн хүн амыг хамруулах асуудал ярвигтай байсаар байна.

Засгийн газрын стратегид тусгахдаа эдгээр өөрчлөлтийн асуудлыг цаашид Мянганы Хөгжлийн Зорилтуудад нэгдмэл байдлаар, Үндэсний хөгжлийн стратегит хэлбэржүүлэн тусгаж шийдвэрлэнэ гэжээ.

Эдийн засгийн санамж бичиг нь Засгийн газрын урт хугацааны хөгжлийн тэргүүлэх зорилтуудыг тодорхойлон зарласан.

Уг санамж бичиг нь төсвийн зардал, хөрөнгө оруулалтын хөтөлбөр, санхүүгийн бодлого мөн бусад стратегиудыг тодорхойлоход засгийн газарт шаардагдах мэдээлэл ба учирч болох үр дагаврын талаар тусгажээ.

Тайланд шинэчлэлийн явцад хөдөлмөр эрхлэлтийг дорвитой нэмэгдүүлэн тогтвортой өсөлтийг хангахад үр ашгаа өгөх салбарууд, тэдгээрийг “хягаарлаж буй хүлээс” чухам хаана байгааг тодорхойлохыг зорилоо. Монгол улсын эдийн засаг дараахь хэлбэрийн хүлээсэнд байна гэж үзлээ. Үүнд : дэд бүтцийн хүнд байдал, татварын гажуудал, гадаад дотоодын уялдаа холбоог хангах хэрэгцээ, өсөн нэмэгдэж буй авилгын үзэгдэл, аливаа гэрээг хэрэгжүүлэхэд үл тохирох албадлага түүнчлэн хөрөнгийн өндөр үнэ зэрэг болно.

Нүсэр бөгөөд гажуудалтай татварын тогтолцоо олон салбарыг хамарсан тухайлбал уул уурхай болон худалдааны үйл ажиллагаа явуулахад мөрдөх нүсэр дэг жаяг, дүрэм нь Монгол улсад бизнес эрхлэхэд бэрхшээл учруулж байна.

Ихэнхдээ цомхон бизнес эрхлэн өндөр татвар төлөхгүй байх эсвэл татвараас зайлсхийх, дутуу дулимаг тайлагнах зэрэг нь татварын дарамтаас үүдсэн нийтлэг үзэгдэл болсон. Статистик мэдээгээр бол татвар оноогдуулалт тэгш бус байгаа бөгөөд засгийн газрын татварын орлогын 90%-ыг тэргүүлэх томоохон 100 татвар төлөгч бүрдүүлдэг гэжээ.

Хөрөнгө оруулагчдын татварт зарцуулсан хугацаа Монголын фирмүүдийн хувьд Оросын фирмүүдээс даруй 3-аас 7 дахин их байна. Татварын байцаагч нар “гөлбөр хайх” ажиллагаа явуулдаг.

Гэсэн хэдий ч 2006 оны 6 сард батлагдсан хууль Монголын татварын захиргаа удирдлагын үйл ажиллагааг олон улсын стандарт туршлагыг мөрдөн ажиллах гүүр болно гэдэгт найдаж байна.

Ядмаг дэд бүтэц бараа материалыг өндөр өртгөөр тээвэрлэх, дамжин өнгөрөх хугацааг уртасгах зэргээр бизнесийн үйл ажиллагаанд зардал учруулдаг ажээ. Фирмүүдийн 38% нь төмөр замын болон газраар ачаа тээвэрлэлтийн ачааны км тутмын үнэ, мөн хилээр хөрш орон руу дайран өнгөрөх ачаа тээвэрлэлтийн өртөг хэт өндөр буюу Азийн далайд гарцгүй бусад орнуудынхаас илүү хэмээн таагүй ханддаг.

Монголын экспортлогчид бизнесээ өргөтгөхгүй байгааг гол учир шалтгаан нь тэдний олон улсын стандартын журмыг баримтлах чадваргүйд оршиж байна. Дотоодын стандартын дүрэм журмыг олон улсын бенчмаркийн нөхцлийг хангах түвшинд хүргэх шаардлагатай. Одоогийн байдлаар Орос улс Монголоос мах импортоор авахыг 2001 онд гарсан малын шүлхий өвчний улмаас хориглосон хэвээр байгаа нь МАА-н салбарт ихээхэн хүндээр тусдаг. Энэ тохиолдолд Монгол улс олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн статустай ижил түвшингийн стандартыг хэрэглэх журам болон мониторингийн тогтолцоог бий болгох нь чухал юм. Судалгааны дүнгээс харахад фирмүүд нь авилга тэдний ажилд гол саад тотгорыг учруулдаг гэж хариулсан 62 орноос 9 дүгээрт нь Монгол улс жагсаж байна.

Дэлхийн Банкнаас явуулсан хөрөнгө оруулалтын орчны судалгаанд лиценз авах зардлын 40% нь хахууль өгөх, албаны бус төлбөр хийхэд зарцуулагддаг гэжээ. Ил тод байдал, хариуцлага тооцох зэрэг ажил дутагдсанаас шалтгаалан газар авсан авилга нь Монгол улсын эдийн засгийн олон секторт бэрхшээл учруулсаар байна. Банкнаас зээл авах хэцүү учраас Монголд эд хөрөнгөтэй болох боломж хязгаарлагдмал. Зээл авагчдын кредитын эрсдлийг үнэлэх чадваргүй байдал нь дампуурал, өрнөөс гарах бэрхшээлтэй нийлээд банкуудыг өндөр хүү, өндөр барьцаатай зээл олгох шаардлага тавихад хүргэдэг ажээ.

Эдгээр хязгаарлалтуудын хүлээс нь хөрөнгө оруулалтын орчинд институцын өөрчлөлтийг хийх, татварын тогтолцоо ба захиргааны удирдлагад суурь өөрчлөлтүүд хийх шаардлагатайг харуулдаг. Хууль, дүрэмд өөрчлөлт оруулах нь шулуун бус замаар явдаг ч эцсийн дүндээ авилгыг таслан зогсоож бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх төдийгүй үр ашигтай санхүүжилтийн хэрэгжилт биелэлээ олно. Авилгыг устгах нь авилгын тэжээгдэж байдаг эх үүсвэрийг таслан зогсоох өөрөөр хэлбэл үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлага тооцох ажлын дутагдлыг арилгахад оршино.

Дэд бүтцэд оршиж буй бэрхшээлийг тодруулах арга нь өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнд, хөрөнгө оруулалтын үйл явцад мониторинг, үнэлгээ хийх юм. Дэд бүтцийн салбар нь эдийн засаг, амжиргааны түвшингийн өсөлтийг бий болгоход чухал үүрэгтэй салбар юм. Бараа материалын импорт, экспортод зам тээврийн тогтолцоог сайжруулах нь бизнесийн салбар цэцэглэн хөгжихөд шууд нөлөөлдөг. Эрчим хүч, ус, ариун цэвэр эрүүл ахуйн үйлчилгээний хангалтын зардлыг үнэ өртөгтэй

нийцүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын удирдлагыг сайжруулах зэрэг нь ядуурлыг бууруулах, эдийн засгийн өндөр үр өгөөж түүнчлэн нийтлэг үр ашигтай ажиллагаанд хүргэх юм. Монголын өсөн нэмэгдэж буй уул уурхайн салбараас орох ашиг нь дэд бүтцийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг санхүүжилтэнд дэмжлэг болно.

Эцэст нь хүний хүчин зүйлийг бага ашиглах, ур чадвар тохирохгүй байх зэрэг ажиллах хүчний асуудлыг хөндөж тавих нь бас нэгэн чухал асуудал юм. Монголчууд хэдийгээр бичиг үсгийн боловсролын түвшин өндөр, зохих хэмжээний боловсролтой ч дэвшилтэт эдийн засгийн шаардлагыг хангах зах зээлийн талбарт ур чадвар нь үл нийцэх байдалтай байна.

Монголын эдийн дэвшлийн чиглэл нь гадаад хэлний мэдлэг, мэдээллийн технологи, техникийн болон зан чанарын мэдлэгүүдийг ихээр шаардах болжээ. Энэхүү хэрэгцээ шаардлага нь боловсролын тогтолцоог ажиллагсад туслахад хандуулахад хүргэснээр хүний хүчин зүйлийн хангалтад ахиц гарч байна.

Зах зээлд шаардагдаж буй ур чадвар болон ажиллах хүчний одоогийн ур чадварыг хооронд нь нийцүүлэх өөрчлөлт хийх хэрэгцээ гарч байна. Үүний зэрэгцээ эдийн засгийн өндөр үр ашгийг авчрах худалдаанд саад учруулалгүй хувийн секторыг дэмжих дүрэм журам болон авилгаас ангид засаглалтай, сайжирсан дэд бүтэц бүхий тогтвортой хөгжлийн өсөлт, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах ажлыг Монгол улс үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай.